



Улсын Их Хурлын саналын дагуу хийсэн
гүйцэтгэлийн аудитын тайлан

МҮОНРТ-ийн 2005 он, 2006 оны эхний хагас жилийн
төсвийн хөрөнгийн зарцуулалт, төрийн өмчийг олон
нийтийн өмчид шилжүүлсэн байдал



ТӨРИЙН ӨМЧИЙГ ДУТУУ ШИЛЖҮҮЛЖЭЭ

Улаанбаатар хот 2006 он

Агуулга

Тайланг бэлтгэсэн:

ҮАГ-ын хоёрдугаар газар

Захирал

О.Мэндбаяр

Аудитын менежер

М.Давааням

Аудитор

Ц.Сугармаа

Аудитор

З.Цээнээ

Аудитор

И.Туяа

2006 оны 12 дугаар сар

Тайланг ҮАГ-ын вэб сайтаас үзнэ үү:

www.mnao.pmis.gov.mn

Аудитын тайлантай
холбоотой асуудлаар нэмж
тодруулах асууж лавлах
зүйл байвал 261675 дугаарын
утас, 323266 дугаарын
факсаар харилцана уу.

ХАЯГ. Үндэсний аудитын
газар. Засгийн газрын 4
дүгээр байр. Бага тойруу-6
Улаанбаатар-46
Монгол Улс

Товчилсон үгсийн жагсаалт.....	2
Танилцуулга.....	3
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, хүндрэл бэрхшээл.....	4

Бүлэг 1

Улсын төсвөөс 2005 он, 2006 оны эхний хагас жилд олгосон хөрөнгийн зарцуулалт

- Батлагдсан төсөв
хэмнэгджээ..... 6
- Өөрийн үйл ажиллагааны орлогыг нэмэгдүүлж,
төсвийн санхүүжилтийг бууруулах
боломж байна..... 7
- Санхүүгийн тайланг бүрэн
нэгтгээгүй байна..... 7
- Зөвлөмж.....9

Бүлэг 2

Өмч хөрөнгийн бүртгэл, ашиглалт

- Техник, тоног төхөөрөмжид шинэчлэл
хийх шаардлагатай байна.....10
- Төрийн өмчийн хороо төрийн өмчийг
хууль бусаар бусдад худалдах,
шилжүүлэх боломж олгожээ.....10
- Сан хөмрөгийн хадгалалт, хамгаалалт
бүртгэлээр тавих хяналт
хангалтгүй байна.....12
- Зөвлөмж.....13

Бүлэг 3

Төрийн өмчийг олон нийтийн өмчид шилжүүлсэн байдал

- Хуульд заасан хэмжээний өмч
хөрөнгийг шилжүүлээгүй байна..... 14
- Зөвлөмж.....14

Холбогдох байгууллагын санал.....15

Хавсралтууд.....18

Аудитаар илэрсэн төлбөр, зөрчлийн нэгтгэл.....22

Товчилсон үгс

УИХ	Улсын Их Хурал
ЗГ	Засгийн газар
ТӨХ	Төрийн өмчийн хороо
МҮОНРТ	Монголын үндэсний олон нийтийн радио, телевиз
РТХЭГ	Радио, телевизийн хэрэг эрхлэх газар
ХМА	Хураамж маркетингийн алба
ҮЗ	Үндэсний зөвлөл
РТДС	Радио телевизийн дээд сургууль
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
УМХГ	Улсын мэргэжлийн хяналтын газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ОНРТ	Олон нийтийн радио телевиз
МҮТ	Монголын үндэсний телевиз
БСШУЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам
ДБРТТ	Дамжуулах байгууламжийн радио телевизийн төв

ТАНИЛЦУУЛГА

Монголын Үндэсний радио, телевиз 1967 онд байгуулагдсан бөгөөд Монгол Улсын Засгийн газрын 2005 оны 241 дүгээр тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг “Радио, телевизийн хэрэг эрхлэх газар”-ыг татан буулгах шийдвэр гарч, Үндэсний олон нийтийн радио, телевиз болгон зохион байгуулжээ. (*Хавсралт № 1-ийг үзнэ үү*)

“Олон нийтийн радио, телевизийн тухай” хуульд зааснаар МҮОНРТ нь олон нийтийн эрх ашигт үйлчилдэг, тэдний өмнө хариуцлага хүлээж, хяналт дор нь үйл ажиллагаагаа явуулдаг ашгийн төлөө бус хуулийн этгээд байж, үндэсний хэмжээнд өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхэлж, сонсогч, үзэгчдэд зориулсан төрөл бүрийн мэдээлэл, сургалт, танин мэдэхүй, хөгжөөн цэнгээх хөтөлбөр, нэвтрүүлэг бэлтгэх, нийтийн хүртээл болгох, монгол орныг дэлхий дахинд сурталчлан таниулах үндсэн чиг үүргийг гүйцэтгэх зорилготой юм.

МҮОНРТ-ийн удирдах дээд байгууллага нь Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөл бөгөөд олон нийтийн ашиг сонирхлыг төлөөлсөн орон тооны бус гишүүнчлэлтэй, 15 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.

Шалгагдсан хугацааны мөнгөн гүйлгээний гарын үсгийн нэгдүгээрийг Б.Ганболд, С.Мягмар, хоёрдугаарыг ерөнхий нягтлан бодогч Н.Тунгалаг, ахлах нягтлан бодогч Д.Баярсайхан, С.Алтанзул, Ч.Тамир нар тус тус зурж төсвийг захиран зарцуулж байжээ.

2005 онд МҮОНРТ-ийн 2003, 2004, 2005 оны эхний хагас жилийг хамруулан Улсын мэргэжлийн хяналтын газраас санхүүгийн шалгалт хийжээ.

Тус шалгалтаар төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан, хүн амын орлогын албан татвар дутуу төлсөн, түрээсийн төлбөрийн зохих хувийг улсын төсөвт төвлөрүүлээгүй, үүрэн телефоны зардлыг батлагдсан төсвөөс хэтрүүлсэн, зарим нэгжийн санхүүгийн ажилтан, эд хариуцагч өмч хөрөнгө дутагдуулж хуулийн байгууллагад шилжүүлсэн зэрэг нийт 111,3 сая төгрөгийн зөрчил дутагдал илэрснээс 20,2 хувийг барагдуулсан байна.

Түүнчлэн 2005 оны санхүүгийн тайланд “Нимм-Аудит” ХХК-ны хийсэн аудитаар нэгжүүдийн гаргасан санхүүгийн тайлан нь санхүүгийн тайлагналын олон улсын стандартын шаардлагад нийцээгүй тул дүгнэлт өгөхөөс татгалзжээ.

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, хүндрэл бэрхшээл

Улсын Их Хурлын санал, Үндэсний аудитын газрын 2006 оны бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Монголын Үндэсний олон нийтийн радио, телевизийн 2005 он, 2006 оны эхний хагас жилийн төсвийн хөрөнгийн зарцуулалт, төрийн өмчийг олон нийтийн өмчид шилжүүлсэн байдалд аудит хийлээ.

Дараахь асуудлыг шалгаж дүгнэлт, зөвлөмж гарган холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдсэн. Үүнд:

- Улсын төсвөөс 2005 он, 2006 оны эхний хагас жилд олгосон төсвийн хөрөнгийн зарцуулалт
- Өмч хөрөнгийн бүртгэл, ашиглалт
- Төрийн өмчийг олон нийтийн өмчид шилжүүлсэн байдал

Аудитад ашигласан шалгуурын эх сурвалж

- Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль
- Олон нийтийн радио, телевизийн тухай хууль
- Төрийн өмчөөс олон нийтийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай хууль
- Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүдийг томилох тухай Улсын Их Хурлын 2005 оны 57 дугаар тогтоол
- ЗГ-ын агентлагийг татан буулгах тухай ЗГ-ын 2005 оны 241 дүгээр тогтоол
- Байгууллагын дүрэм, журам, эрх зүйн акт, Үндэсний зөвлөлийн шийдвэр болон бусад холбогдох бичиг баримт

Аудитын стандартын талаархи мэдэгдэл

Аудитын явцад асуудлыг шинжлэх, холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, тайлбар мэдээ гаргуулах, санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг судлах, нөхцөл байдлын шинжилгээ хийх зэрэг гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашиглалаа.

Гүйцэтгэлийн аудитыг хийхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, түүнийг хэрэгжүүлэх аргачилсан зөвлөмж, Гүйцэтгэлийн шалгалтын журам, Гүйцэтгэлийн аудитын гарын авлага, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийг мөрдлөг болгон аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж, дүгнэлт зөвлөмж боловсруулав.

Аудитын явцад дараахь хүндрэл бэрхшээл учирч байлаа. Үүнд:

- “Төрийн өмчөөс олон нийтийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай” хуулийг боловсруулахад ашигласан санхүүгийн болон холбогдох мэдээлэл, эд хөрөнгийн жагсаалтыг МҮОНРТ болон ТӨХ -ноос гаргаж өгөөгүй.

- Төрийн өмчөөс олон нийтийн өмчид эд хөрөнгө шилжүүлж хүлээлцсэн талаар илтгэх хуудас байхгүй, холбогдох хуульд заасан дүнгээс зөрүүтэй байдлаар хүлээлцсэн талаар ТӨХ-ны Төрийн өмчийн удирдлага, хувьчлалын газрын дарга Ц.Нанзаддорж тайлбар өгөөгүй
- РТХЭГ/хуучин нэрээр/-ын дарга, ерөнхий нягтлан бодогч нар удаа дараа солигдсон, орлож байсан зарим нягтлан бодогч тайлан дахь дүнгээ тайлбарлаж мэдэхгүй байснаас гадна нэгдсэн тайланг бэлтгэсэн, нэгтгэл хийхэд ашигласан ажлын хүснэгт, баримт материал байхгүй учир санхүүгийн тайлан үнэн зөв эсэх нь эргэлзээтэй байна.
- Нягтлан бодогч, эд хариуцагч амарчихсан, ерөнхий нягтлан бодогч О.Сүхбаатар шинээр ажил авсан учир 2005 он, 2006 оны эхний хагас жилийн санхүүгийн ажил гүйлгээ, баримтын талаар тайлбар өгч чадахгүй байлаа.

Батлагдсан төсөв хэмнэгджээ

1.1 МҮОНРТ-ийн 2005 оны урсгал зардалд 5760,4 сая төгрөг, 2006 оны эхний хагас жилийн урсгал зардалд 2627,6 сая төгрөг батлагдсанаас гүйцэтгэлээр 2005 онд 5428,7 сая төгрөг, 2006 оны эхний хагас жилд 2321,7 сая төгрөг зарцуулж, төсвийг 2005 онд 331,7 сая төгрөгөөр, 2006 оны эхний хагас жилд 305,9 сая төгрөгөөр тус тус хэмнэжээ.

**МҮОНРТ-ийн төсвийн зардлын гүйцэтгэл
(2005 он, 2006 оны эхний хагас жил)**

/сая төгрөгөөр/

Зардлын дүн	2005 он			2006 оны эхний хагас жил		
	төл	гүйц	хэтрэлт/-/ хэмнэлт/+	төл	гүйц	хэтрэлт/-/ хэмнэлт/+
I. Нийт зардлын дүн	5760,4	5428,7	331,7	2627,6	2321,7	305,9
Ажиллагсадтай холбогдсон зардал	1533,5	1525,5	8,0	916,1	811,1	105,0
Бараа үйлчилгээний зардал	4200,0	3786,4	413,6	1706,2	1493,5	212,7
Татаас ба урсгал шилжүүлэг	26,9	12,4	14,5	5,3	17,1	-11,8
Хөрөнгийн зардал		104,4	-104,4			
II. Зардлын эх үүсвэр	5760,4	5471,7	288,7	2426,9	2542,0	-115,1
Улсын төсвөөс	3319,5	3347,6	-28,1	1819,9	1819,9	0
Үндсэн үйл ажиллагааны орлого	2344,4	2010,9	333,5	575,9	692,8	-116,9
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	96,5	113,2	-16,7	31,1	29,3	1,8

1.2 Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулалд 2005 онд 1217,3 сая төгрөг төлөвлөж, гүйцэтгэлээр 1219,0 сая төгрөг, 2006 оны эхний хагас жилд 749,5 сая төгрөг төлөвлөж, гүйцэтгэлээр 621,7 сая төгрөг зарцуулжээ. 2006 оны эхний хагас жилийн байдлаар 127.8 сая төгрөг хэмнэсний 51 сая төгрөгийн цалингийн нэмэгдлийг 3 дугаар улиралд нөхөж олгосон байна /ЗГын 147 тогтоолоор нэмэгдсэн төрийн албан хаагчийн цалингийн нэмэгдэл/.

1.3 2005 онд нийт зардлын 30,8 хувь буюу 1737,5 сая төгрөг холбооны шугам дамжуулах сүлжээ ашигласны болон олон улсын суваг ашигласны төлбөрт хуваарилагдаж гүйцэтгэлээр 1674,2 сая төгрөг зарцуулж, 63,3 сая төгрөг хэмнэжээ.

1.4 2006 оны эхний хагас жилд нийт зардлын 35,1 хувь буюу 921,8 сая төгрөг холбооны шугам дамжуулах сүлжээ ашигласны болон олон улсын суваг ашигласны төлбөрт хуваарилагдаж гүйцэтгэлээр 805,5 сая төгрөг зарцуулж 116,3 сая төгрөг хэмнэжээ. Гэхдээ олон улсын суваг ашигласны төлбөрийг 88,9 сая төгрөгөөр дутуу төлсөн байна.

1.5 2005 онд уран бүтээлийн зардалд 396,7 сая төгрөг хуваарилж, гүйцэтгэлээр 376,5 сая төгрөг зарцуулж 20,2 сая төгрөг хэмнэжээ. Уран бүтээлийн зардлын 41,3 хувийг зөвхөн зуучийн хөлсөнд зарцуулжээ.

1.6 РТХЭГ нь ОНРТ-ийн тухай хуулиар МҮОНРТ болон өөрчлөгдсөн байхад ММ агентлаг, МҮТ, Радиогийн захирлуудын 2000-2004 онд баталсан Шагнал урамшуулал олгох журмуудыг өнөө хүртэл мөрдөж байна. Тухайлбал, уран бүтээлийг хийхэд оролцсон уран бүтээлчдэд олгох урамшуулал, төлбөртэй нэвтрүүлэг олж зуучилсны хөлсөнд олгох зуучийн хөлс зэрэг шагнал урамшууллыг давхардуулан олгож байна. Зуучийн хөлсний тарифыг өндөр тогтоосноос үргүй зардал их гарч уран бүтээл хийх зардал багасч байна.

1.7 Дээрх шагнал урамшууллын хэмжээг нэгжүүд 10-30 хувийн хооронд харилцан адилгүй тогтоосон байна.


Өөрийн үйл ажиллагааны орлогыг нэмэгдүүлж, төсвийн санхүүжилтийг бууруулах боломж байна

1.8 МҮОНРТ-ийн санхүүжилт “олон нийтийн радио, телевизийн тухай” хуульд заасан дараахь эх үүсвэрээс бүрдэнэ. Үүнд:

- радио, телевизийн нэвтрүүлгийн үйлчилгээний хөлс
- тоног төхөөрөмж, бусад эд хөрөнгө түрээслүүлсний орлого
- хандив тусламж
- улсын төсвийн дэмжлэг
- бусад эх үүсвэр

1.9 РТХЭГ нь МҮОНРТ болон өөрчлөгдсөн боловч улсын төсвийн санхүүжилтийг /2005 онд 3319,5 сая төгрөг, 2006 онд 4004,3 сая төгрөг/ урьдын адил авсаар байна. Энэ нь ОНРТ-ын тухай хуулийн 17.1.5-д заасан **төсвийн дэмжлэг** гэж тэр бүр харагдахгүй, үндсэн эх үүсвэр хэвээр байна.

МҮОНРТ-ийн нийт орлогын бүтэц (2005 он 2006 оны эхний хагас жил)



1.10 Үндэсний статистикийн газар, МҮОНРТ-ийн ХМА-аас гаргасан судалгаанаас үзэхэд өнөөгийн байдлаар улсын хэмжээний нийт телевизорын 45-50 хувь нь үйлчилгээний хөлс төлж байна. Нийт телевизорын 70 хувийг хамруулж төлбөр авна гэж тооцоход 670-680 сая төгрөгөөр орлого нэмэгдүүлэх боломж байна. (хүснэгт № 3-ыг үз)

Санхүүгийн тайланг бүрэн нэгтгээгүй байна

1.11 МҮОНРТ-ийн 2005 он, 2006 оны эхний хагас жилийн санхүүгийн нэгдсэн тайланд ХМА-ны хадгаламж дахь мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл, орон нутаг дахь салбар нэгжийн хөрөнгө, орлого зардлын гүйцэтгэлийг огт тусгаагүй, хураамжийн орлогыг Улаанбаатар хот, орон нутгийн хэмжээгээр авлага үүсгэн бүртгээгүй, зөвхөн дансанд тушаагдсан мөнгөн дүнгээр орлогыг бүртгэж байна.

1.12 МҮОНРТ мэдээллийн технологийг үйл ажиллагаандаа хангалтгүй ашиглаж, НББ-ийн програм байхгүй, нэгдсэн санхүүгийн тайланг бэлтгэхэд ашиглах бүртгэлийн бодлогогүй, нэгтгэл хийхэд ашигласан ажлын хүснэгт, баримтгүй, зөвхөн Excel програм дээр арифметик үйлдлээр нэмж хасах байдлаар гаргаж байна.

1.13 2005 онд улсын төсвөөс урсгал засварт 3319,5 сая төгрөг, 2006 оны эхний хагас жилд 1819,9 сая төгрөг олгож, бүрэн авч зарцуулжээ.

1.14 Төсвийн хөрөнгийн зарцуулалтад хийсэн аудитаар дараахь зөрчил илэрлээ.

- 2005 он, 2006 оны эхний хагас жилд 309.3 сая төгрөгийн сэлбэг, бараа материал, тоног төхөөрөмжийг хувь хүн, аж ахуйн нэгж, байгууллагаас тендер шалгаруулалгүй, шууд худалдан авч “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмын тухай” хуулийг зөрчжээ. (*Хавсралт № 2-ыг үз*).
- 2002 онд “Вагнер-Ази” ХХК-аас 44 сая төгрөгөөр авсан Форд-Экспедишн 03-83 УБЗ маркийн авто машинд 2005 он, 2006 оны эхний хагас жилийн байдлаар сэлбэг, үйлчилгээнд 14,2 сая төгрөг, шатахуунд 9,5 сая төгрөг, нийт 23, 7 сая төгрөг зарцуулжээ.
- 2005 оны 2 дугаар сард “Силикон Софт” ХХК-тай Нягтлан бодох бүртгэл санхүүгийн програм нэвтрүүлэхээр 3,5 сая төгрөгийн ажлын гэрээ хийж /гэрээ хийсэн хоёр талын албан тушаалтны гарын үсэггүй, тамга тэмдэггүй/ урьдчилгаанд 2,0 сая төгрөг олгосон боловч гүйцэтгэгч тал гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тул “Силикон Софт” ХХК-иар урьдчилгаанд олгосон мөнгийг төлүүлэх нь зүйтэй гэж үзэв.
- 2006 оны 3 дугаар сард “Скай Си энд Си” ХХК-аас байгууллагын дотоод сүлжээ, интернетийн холболтод зориулж утасгүй сүлжээний адаптор 40 ширхэгийг 4,6 сая төгрөгөөр авсан боловч огт ашиглаагүй байна.
- Санхүү бүртгэлийн ажилтнуудын ажлын үр дүнг үнэлэх, дүгнэх журамгүйгээр 2005 он, 2006 оны эхний хагас жилийн байдлаар улирал бүр сарын цалингийн 70-90 хувиар бодож дарга, нягтлан бодогч, эд хариуцагч, тайз засагч нарт балансын шагнал нэрээр нийт 16,3 сая төгрөгийн шагнал, урамшуулал олгожээ. Энэ нь Санхүү, Эдийн засгийн сайдын 2002 оны 210 дугаар тушаалын хавсралт 3.1-д “Аж ахуйн нэгж байгууллага нь өөрийн онцлогт тохирсон, санхүү, бүртгэлийн ажилтнуудыг үнэлж дүгнэж, шагнал урамшил олгох журмыг баталж мөрдүүлнэ”, хавсралт 3-т “Төсөвт байгууллагын бүртгэл тооцооны ажилтны ажлыг дүгнэх үндсэн үзүүлэлтүүд”-д заасан шаардлагыг хангасан нөхцөлд урамшил олгоно гэсэн заалтыг зөрчжээ.
- МҮОНРТ-ийн ерөнхий захирлын 2006 оны 302 дугаар тушаалаар “Өргөн булаг” амралтын газрыг телевизийн нэвтрүүлгийн үйлдвэрлэлд ашиглах зорилгоор “Зураг авалтын талбар болгох” төслийг хэрэгжүүлэх менежментийн багийн ахлагчаар “Титэм” студийн редактор С.Дашнямыг 2006 оны 6 дугаар сарын 9-ний өдрөөс томилжээ. Гэвч энэ багийн хийсэн ажил тодорхойгүй, тус амралтыг 3 сарын хугацаанд ажиллуулсан

боловч орлого зарлагын тооцоог бодож тайлан тэнцэлд тусгаагүй байлаа.

- МРТХЭГ-ын даргын 2000 оны А/130 дугаар тушаалаар “Хэмнэлтийн урамшууллын сан” байгуулах, түүнийг зарцуулах журмыг баталсан боловч санг байгуулж эх үүсвэрийг бүрдүүлээгүй байхад дээрх тушаалыг үндэслэн 2006 оны 3 дугаар улирлыг хүртэлх хугацаанд Хэрэг эрхлэх газрын захиргааны ажилтнуудад урамшуулал олгож төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулж иржээ. 2005 он, 2006 оны эхний хагас жилд олгосон нийт 6,1 сая төгрөгийг нөхөн төлүүлэх нь зүйтэй гэж үзэв. (Хавсралт № 4-ыг үз)
- 2006 онд тушаал шийдвэргүйгээр “МТ” кино нэгтгэлийн менежер Д.Цэцэг их зохиолч Д.Нацагдоржийн 100 жилийн ойн баримтат кино хийхээр олгосон санхүүжилтээс 1,9 сая төгрөгөөр 1000 ширхэг хуанли хэвлүүлж, зориулалт бусаар хөрөнгийг зарцуулжээ.
- 2005 онд санхүүгийн тайланд аудитын дүгнэлт хийлгэхээр 20,0 сая төгрөгийн гэрээг тендер шалгаруулалгүй “НИММ-Аудит” ХХК-тай байгуулж 10,0 сая төгрөг зарцуулсан байна.

ЗӨВЛӨМЖ

МҮОНРТ-ийн ерөнхий захирал М.Наранбаатарт:

- Телевизийн үйлчилгээний хөлсийг аль болох бүрэн төвлөрүүлэх, санхүүжилтийн бусад эх үүсвэрийг ашиглах арга хэмжээ авах
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмын тухай хуулийг мөрдөж, худалдан авалтаас хөрөнгө мөнгө хэмнэж ажиллах
- Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан мөрдүүлж, санхүүгийн тайлан тэнцлийг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын аргачлал, зааврын дагуу гаргаж байх

Техник, тоног төхөөрөмжид шинэчлэл хийх шаардлагатай байна

2.1 Монголын Үндэсний Радио 1988 онд Унгар улсад үйлдвэрлэсэн аналог системийн тоног төхөөрөмж ашиглаж байгаа бөгөөд энэ нь одоо үйлдвэрлэхээ больсон, сэлбэг олдоцгүй болсон төдийгүй эфирт саатал, гологдол гарч, хөдөө орон нутагт радиогийн сонсгол, хамрах хүрээ муудахад хүргэж байна. Суурин төхөөрөмжүүд 1980-1988 онд ашиглалтад орсон бөгөөд одоо үйлдвэрлэлээс хасагдсан, орон орны хэдэн өөр форматын PAL, SECAM систем холилдсон технологитой тул олон дахин хувиргалт хийх шаардлага гарч ашиглалтыг хүндрүүлж байна.

2.2 Радио телевизийн анхны төв 1967 онд ашиглалтад орсон бөгөөд тус төвийг цахилгаан эрчим хүчээр 1966 оны загварын 2 талын тэжээлтэй дэд станц хангадаг. Энэ 2 станцын эд анги олдохоо больжээ.

2.3 Радио телевизийн технологийн аналог системийг нэгдсэн тоон сүлжээнд шилжүүлж, техник, тоног төхөөрөмжийг шинэчилснээр нэвтрүүлэг бэлтгэх шат дамжлага цөөрч, зардал, цаг хугацаа хэмнэгдэж, нэвтрүүлгийн чанар сайжрах боломжтой юм.

2.4 Үндэсний зөвлөл олон нийтийн радио, телевизийн техник, технологийг хөгжүүлэх, техникийн хангамжийн бодлогыг тодорхойлох шаардлагатай байна.

Төрийн өмчийн хороо төрийн өмчийг хууль бусаар бусдад худалдах, шилжүүлэх боломж олгожээ

2.5 РТХЭГ /хуучин нэрээр/ 2005 оны 5 дугаар сарын 9-нд барилгын хүзүүвч нэрээр бүртгэгдсэн барилгыг Радио, телевизийн дээд сургуульд балансаас балансад шилжүүлэх шийдвэр гаргуулахаар ТӨХ-нд хандсан байна.

2.6 ТӨХ-ноос ирүүлсэн албан бичигт РТХЭГ-ын үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй контор, студийн зориулалттай дуусаагүй барилгыг урт хугацаагаар түрээслүүлэх болон худалдах асуудлыг хууль дүрэмд нийцүүлэн өөрсдөө шийдвэрлэх нь зүйтэй гэж дурдсаны үндсэн дээр доорхи хөрөнгийг худалдан шилжүүлжээ.

а. Төрийн өмчийн байрыг дуудлага худалдаа зохион байгуулалгүй, үнэ бууруулж, бусдад худалдан шилжүүлсэн байна

2.7 РТХЭГ-ын даргын 2005 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 246 дугаар тушаалаар 147,8 сая төгрөгийн өртөгтэй барилгын хэсгийг Радио, телевизийн дээд сургуульд үнэ төлбөргүй шилжүүлжээ.



Зураг 1. Радио, телевизийн дээд сургуулийн барилга

2.8 БСШУ-ны сайдын 2006 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн тушаалаар дээрх сургуулийн харъяаллыг хүчингүй болгож, Радио, телевизийн дээд сургууль болгон өөрчилж, тус яамны харъяа болгосон боловч төсөв нь БСШУ-ны сайдын

төсвийн багцад ордоггүй, санхүүгийн нэгдсэн тайланд хөрөнгийг нэгтгэж тайлагнадаггүй байна.

2.9 РТХЭГ-ын даргын 2005 оны 6 дугаар сарын 30-ний өдрийн 152 дугаар тушаалаар 482,9 сая төгрөгийн өртөгтэй контор, студийн зориулалттай дуусаагүй барилгыг үнэ бууруулж 150,0 сая төгрөгөөр “Супер Вижн” ХХК-д худалджээ.



Зураг 2 . “Супер-Вижн” ХХК-д худалдсан дуусаагүй барилга ашиглалтанд орсон байдал



Зураг 3. Гаражын гадаад байдал

2.10 РТХЭГ-ын даргын 2005 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн 275 дугаар тушаалаар 15,6 сая төгрөгийн гражийн барилгыг хашааны хамт 20,0 сая төгрөгөөр “Коума” ХХК-д худалджээ.

2.11 “Супер Вижн” ХХК-д худалдсан дуусаагүй барилгын үнэ 150.0 сая төгрөгийг РТХЭГ-ын дэд дарга асан Ш.Батбаяр бэлнээр авч дараахь зүйлд зарцуулжээ. Үүнд:

Худалдан авалт, ажил үйлчилгээг гүйцэтгэхдээ дуусаагүй барилгын үнийг данс бүртгэлд тусгаагүй, байгууллагын дарга, нягтлан бодогчийн зөвшөөрөлгүй зөвхөн өөрийн гарын үсгээр, хүчин төгөлдөр бус бэлэн мөнгөний баримтаар зарцуулж “Нягтлан бодох бүртгэлийн тухай” хуулийн 2 дугаар бүлгийн 9.1-дэх /Аж ахуйн нэгж, байгууллага нь хөрөнгө, өр төлбөрөө нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэлж дансанд бүртгэнэ/-заалтыг зөрчсөн байна.

Зарцуулалт	Дүн
<i>Цайны газрын засварт</i>	11,620,000.00
<i>Барилгын засварт</i>	101,752,651.00
<i>Тоёота прадо машин</i>	8,000,000.00
<i>Портер машин</i>	2,500,000.00
<i>Микроавтобус</i>	2,500,000.00
<i>Тоног төхөөрөмж</i>	3,880,000.00
<i>Делика машин</i>	6,677,000.00
<i>Мицубиши Галлант машин</i>	4,107,950.00
Бүгд дүн	141,037,601.00

2.12 Тоёота прадо машиныг 8000.0 мянган төгрөгөөр, микроавтобусыг 2500.0 мянган төгрөгөөр тус тус худалдаж авсан боловч үндсэн хөрөнгийн бүртгэлд тоёота прадо машиныг 13176.0 мянган төгрөг, микроавтобусыг 3500.0 мянган төгрөгөөр үнэлж тусгасан, Ш.Батбаяр өөрийн албан хэрэгцээнд ашиглагдаж байсан 15.0 сая төгрөгийн өртөгтэй Ланд крузер-80 маркийн машиныг 5.0 сая төгрөгөөр зарж дээрх Тоёота прадо машины үнэнд оруулж авсан гэх боловч үүнийг нотлох орлогын баримт байхгүй, машиныг данс бүртгэлээс хасчээ.

2.13 МҮОНРТ-ийн удирдлагаас Улсын мөрдөн байцаах газарт “Супервижн” ХХК-д худалдсан дуусаагүй барилга, Радио, телевизийн дээд сургуульд үнэ төлбөргүй шилжүүлсэн хүзүүвч барилга, автограж, аж ахуйн хашаа зэргийг буцаан авч байгууллагыг хохиролгүй болгох нэхэмжлэлийг өгснөөр РТХЭГ-ын дарга асан Б.Ганболд, дэд дарга асан Ш.Батбаяр нарт албан тушаалын эрх мэдлээ хэтрүүлэн хууль зөрчиж их хэмжээний хохирол учруулсан гэх үйлдэлд нь 2006 оны 5 дугаар сарын 2-ны өдөр эрүүгийн хэрэг үүсгэн шалгажээ. Гэвч уг хэргийг 2006 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн Өршөөл үзүүлэх тухай хуулийн 7.1-д заасныг үндэслэн Нийслэлийн прокурорын 2006 оны 9 дүгээр сарын 29-ны өдрийн 151 дүгээр тогтоолоор хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ.

б. Автомашинуудыг үнэ бууруулан худалджээ

2.14 РТХЭГ /хуучин нэрээр/ 2005 онд авто тээврийн хэрэгслийг худалдан авах, данснаас хасахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасан эрх бүхий байгууллагын шийдвэр гаргуулаагүй байна.

2.15 РТХЭГ 2005 онд 85,0 сая төгрөгийн авто тээврийн хэрэгслийг орлого болгож, 217,6 сая төгрөгийн автотээврийн хэрэгслийг данснаас хассаны дотор 92,4 сая төгрөгийн өртөгтэй 12 автомашиныг дуудлага худалдаа зохион байгуулалгүй, үнэ бууруулж 24,1 сая төгрөгөөр худалджээ.

2.16 Монголын Радиогийн хэрэгцээнд ашиглагдаж байсан 8,5 сая төгрөгийн өртөгтэй “Нубира” маркийн машиныг Радиогийн даргын шийдвэрээр 1,6 сая төгрөгөөр худалдаж, орлогыг бүртгэлд тусгалгүй шинээр автомашин худалдаж авахад зарцуулсан байна.

2.17 2006 оны эхний хагас жилийн байдлаар гаргасан авто тээврийн тооллогын бүртгэлээс зарим машиныг тулгаж үзэхэд 450,0 мянган төгрөгийн өртөгтэй чиргүүл, 1800,0 төгрөгийн өртөгтэй Паз автобус огт байхгүй, автобусыг түрээсээр ашиглуулдаг гэсэн тайлбар өгсөн боловч холбогдох гэрээ баримт байхгүй учир Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 2 дугаар бүлгийн 9.4-д /Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллага үрэгдүүлж, дутаасан хөрөнгийн тооцоог түүний өртөг болон зах зээлийн үнийн аль өндрөөр хийнэ/ заасны дагуу үнэлүүлж төлүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

2.18 Ийнхүү төрийн өмчийг дур мэдэн худалдсан, шилжүүлсэн, худалдан авсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 1-д заасан “Төрийн өмчийн үл хөдлөх хөрөнгийг хувьчлалаас гадуур худалдахад Засгийн газрын, төрийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөнд хамаарах хөдлөх хөрөнгийг Төрийн өмчийн хорооны, бусад эд хөрөнгийг тухайн хуулийн этгээдийн шийдвэрээр гагцхүү дуудлага худалдаагаар худалдаж болно”, мөн хуулийн 30 дугаар зүйлийн 3-д “..төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр хандивлах, бэлэглэх, барьцаалах, зээлдүүлэх, бусад өмчийн хуулийн этгээдэд хувь хөрөнгө болгон оруулахыг хориглоно” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

2.19 Тус байгууллагын удирдлага, нягтлан бодогч нар ажилдаа хариуцлагагүй хандаж, хөрөнгө мөнгийг бүртгэлд тусгахгүй бэлнээр авч зарцуулан, өмч хөрөнгөд бүртгэлээр тавих хяналтыг сулруулсан нь бусдад хөрөнгө мөнгө завших боломжийг бүрдүүлжээ.

2.20 Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 28.1-д Олон нийтийн радио, телевизийн хөтөлбөрийн бодлогоос бусад асуудлаар гарсан Үндэсний зөвлөлийн шийдвэрийн хэрэгжилт, олон нийтийн радио, телевизийн санхүү, аж ахуйн үйл ажиллагаа, менежментэд хяналт тавих чиг үүрэг бүхий хяналтын зөвлөл ажиллана, Хяналтын зөвлөл нь хуулийн 29.1.1-д зааснаар Үндэсний зөвлөлийн дарга, гишүүнийг эгүүлэн татах тухай зөвлөмж гаргах эрхтэй байна гэж заажээ. Гэтэл Хяналтын зөвлөлийн гишүүдийг Үндэсний зөвлөлийн гишүүд дотроос томилсон нь тэдгээрийн хараат бус байдлын зарчимтай нийцэхгүй байна.

Сан хөмрөгийн хадгалалт хамгаалалт, бүртгэлээр тавих хяналт хангалтгүй байна

2.21 МҮОНРТ-ийн Үндэсний зөвлөлийн 2006 оны 55 дугаар тогтоолоор “МҮОНРТ-ийн телевиз, радиогийн нэвтрүүлгийн баримт /алтан фонд/-ыг бүрдүүлэх, хадгалах, хамгаалах, нөхөн бүрдүүлэх, ашиглах журмыг баталсан байна.

2.22 Журмаар “Сан хөмрөг нь Монголын ард түмний амьдрал хөгжлийн түүхийг тусгасан, эрдэм шинжилгээ нийгэм, улс төр, эдийн засаг, соёлын ач холбогдол бүхий бүх төрлийн нэвтрүүлгээс бүрдэх ба салбарын алдар гавъяатнууд, нэрт зүтгэлтнүүдийн дүрс, дуу хоолой, дурсамж яриа, ардын авъяастнуудын дахин давтагдашгүй бүтээл туурвил, уран бүтээлчдийн баримт материалуудаас бүрдсэн Монголын ард түмний түүх соёлын үнэт өв” гэж тодорхойлжээ.

2.23 Алтан фондын хадгалалт хамгаалалттай танилцахад ашиглалтын бүртгэл хангалтгүй, гар нооргоор хөтөлсөн, хариуцсан нягтлан бодогч хяналт тавьдаггүй, хальсны бүрэн бүтэн байдлыг шалгах төхөөрөмжгүй, чийг, дулаан хэмжигч багаж хэрэгсэл байхгүй, зөвхөн саванд ус хийж чийгшүүлж байна.

2.24 Радиогийн хөгжмийн эргэлтийн сан хөмрөгт ардын дуу 4000, зохиолын дуу 10000, хөгжмийн уран сайхны нэвтрүүлэг 300, гадаад бичлэг 10000 зэрэг нийт 25000 орчим хальс хадгалагдаж байна. Радиогийн эфирийн тоног төхөөрөмж CD шууд ашиглах боломжгүй учраас хальс руу хөрвүүлэн хэрэглэж байна.



Зураг 3. Сан хөмрөгийн хадгалалтын байдал

2.25 Радиогийн алтан болон эргэлтийн сан хөмрөгийн бүтээлүүдийг нягтлан бодох бүртгэлд огт тусгадаггүй байна.

2.26 Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 10.2-т олон нийтийн радио, телевизийн архив Үндэсний төв архивын салбар бөгөөд уг архивт архивын баримтыг бүрдүүлэх, хадгалах, нөхөн бүрдүүлэх, ашиглахтай холбогдсон харилцааг Архивын тухай хуулиар зохицуулна гэж заасан боловч Үндэсний төв архивын салбар болох талаар ажил огт хийгдээгүй байна.

ЗӨВЛӨМЖ

МҮОНРТ-ийн Үндэсний зөвлөлийн дарга Х.Чилаажавт:

- ОНРТ-ийн техник, технологийг хөгжүүлэх, техникийн хангамжийн бодлогыг тодорхойлж, техник, технологийг шинэчлэх арга хэмжээ авах

МҮОНРТ-ийн ерөнхий захирал М.Наранбаатарт:

- Радио, телевизийн сан хөмрөгийг үнэлж бүртгэх, зориулалтын багаж төхөөрөмжөөр хангах, Үндэсний төв архивын салбар болгох ажлыг зохион байгуулах
- Радиогийн алтан болон эргэлтийн сан хөмрөгийн бүтээлүүдийг нягтлан бодох бүртгэлд тусгах
- Санхүү бүртгэлийн ажилтнуудын мэргэшил, ур чадварыг дээшлүүлэх

Хуульд заасан хэмжээний өмч хөрөнгийг шилжүүлээгүй байна

3.1 Төрийн өмчөөс олон нийтийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай 2005 оны 1 дүгээр сарын 27-нд батлагдсан 3 зүйл бүхий хуулиар 2005 оны 1 дүгээр сарын 1-ний өдрийн байдлаар РТХЭГ-ын эзэмшилд байгаа 5248,2 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, 272,9 сая төгрөгийн эргэлтийн хөрөнгийг олон нийтийн өмчид шилжүүлэхээр заажээ.

3.2 Гэтэл хуульд заасан дүнгээс үндсэн хөрөнгийг 194,1 сая төгрөгөөр дутуу шилжүүлсэн байна.

3.3 РТХЭГ-ыг татан буулгах тухай ЗГ-ын 2005 оны 241 дүгээр тогтоолыг үндэслэн ТӨХ-ны төрийн өмчийн удирдлага, хувьчлалын газрын дарга Ц.Нанзаддоржоор ахлуулсан комисс томилогдож РТХЭГ-ын ашиглаж байсан төрийн өмчийг Үндэсний зөвлөлд шилжүүлжээ. Уг комисс хөрөнгийг хүлээлцүүлэхдээ хөрөнгийн биет тооллого хийж, тооцоог бодож хүлээлцүүлээгүй, 2005 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар гаргасан тайлан тэнцлийн дүнгээр товчоо хийж гарын үсэг зурж шилжүүлжээ.

3.4 Төрийн өмчийн хороо хуульд заасан хөрөнгийн хэмжээнээс зөрсөн дээрх байдлыг тодруулж тайлбарлан илтгэх хуудас, тайлан бичээгүй байна.

3.5 2005 оны 7 дугаар сарын 1-нээс Олон нийтийн радио телевизийн тухай хууль хүчин төгөлдөр болсон, УИХ-аас Үндэсний зөвлөлийн гишүүдийг 2005 оны 10 дугаар сарын 13-нд томилсон, РТХЭГ-ыг татан буулгах ЗГ-ын тогтоол 2005 оны 12 дугаар сарын 7-нд гарсан, хөрөнгийг 2006 оны 2 дугаар сарын 6-нд шилжүүлсэн нь өмч хөрөнгийг хуульд заасан дүнгээр шилжүүлэх боломжгүй болгожээ.

3.6 Төрийн өмчөөс олон нийтийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай хуульд зааснаар РТХЭГ-ын эзэмшилд байсан Дамжуулах байгууламжийн радио, телевизийн техникийн төв буюу Хонхор дахь радио нэвтрүүлэх төв станц, Баян-Өлгий, Говь-Алтай, Дорнод, Өмнөговь, Хөвсгөл аймаг дахь радио өргөн нэвтрүүлгийн станцуудыг олон нийтийн өмчид шилжүүлээгүй үлдээжээ.

3.7 РТХЭГ болон Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн газрын даргын 2005 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн 233/116 дугаар тушаалаар ДБРТТ-ийн төвийг татан буулгаж, Мэдээлэл, харилцаа, хөгжлийн төвд шилжүүлэх ажлын комиссыг томилж хөрөнгийг шилжүүлсэн байна.

ЗӨВЛӨМЖ**ТӨХ-ны дарга Д.Сугарт:**

- Төрийн өмчөөс олон нийтийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай хуульд заасан өмч хөрөнгийн дүн болон МҮОНРТ-д хүлээлгэн өгсөн хөрөнгийн дүн зөрсөн шалтгааныг судалж, зохих журмын дагуу шийдвэрлүүлэх

Холбогдох байгууллагын санал

МҮОНРТ-ийн Үндэсний
зөвлөлийн санал

МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ОЛОН
НИЙТИЙН РАДИО, ТЕЛЕВИЗИЙН
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ

210524 Улаанбаатар хот, Баянгол дүүрэг,
Хувьсгалын зам 3, Утас/Факс: 36-47-19,
E-mail: mnprtv@magicnet.mn

МУ-ЫН ҮНДЭСНИЙ АУДИТЫН
ГАЗАРТ

2007.01.11 № 03
танай _____-ны № _____-т

Санал хүргүүлэх тухай

Тус газраас "МҮОНРТ-ийн 2005 он, 2006 оны эхний хагас жилийн төсвийн хөрөнгийн зарцуулалт, төрийн өмчийг олон нийтийн өмчид шилжүүлсэн байдал"-д хийсэн аудитын тайлантай танилцлаа.

Та бүхний зөвлөмж болгосон "Хяналтын зөвлөлийн гишүүдийг Олон Нийтийн Радио, Телевизийн тухай хуульд нийцүүлэн томилох" гэсэн зөвлөмжид дараах хариуг өгч байна.

ОНРТ-ийн тухай хууль батлагдаж түүнийг дагаж мөрдсөний дагуу УИХ-аас Үндэсний Зөвлөлийн гишүүдийг томилж, УИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хорооноос МҮОНРТ-ийн Үндэсний Зөвлөлийн анхдугаар хуралдааныг удирдан зохион байгуулж, тухайн өдөр Үндэсний зөвлөлийн даргаар Н.Содномдоржийг томилж, Хяналтын зөвлөл болон Өргөдөл шалгах хороог тус тус байгуулж өгсөн юм.

Нэгэнт Төрийн эрх мэдэл бүхий байгууллагаас байгуулж, бүрэлдэхүүнийг сонгож баталсан асуудлыг буруутгах ямар нэг үндэслэлгүй гэж үзэж байна. Учир нь ОНРТ-ийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2 дахь хэсэгт Хяналтын зөвлөлийн гишүүдийг хаанаас сонгох тухай асуудлыг хуульчилж өгөөгүй байна.

Анхдугаар хуралдаанаар Үндэсний Зөвлөлийн гишүүдээс Хяналтын зөвлөлийн гишүүдийг сонгож томилсон явдал нь хууль зөрчсөн буюу хуульд нийцээгүй гэж үзэх үндэслэл харагдахгүй байна.

Энэхүү асуудлаар УИХ-ын байнгын хорооны шалгалтын хэсгийн зөвлөмжийн хариуд тодорхой тайлбар гаргаж өгсөн бөгөөд манай байгууллагын зүгээс уг асуудлаар албан ёсны тайлбар гаргуулахаар Улсын Дээд Шүүхэд хандахаар бэлтгэж байна.

Тайлбар 1-ийг үзнэ үү.



ДАРГА

С. Цагаар

Х.ЧИЛААЖАВ

190026

МҮОНРТ-ийн санал



**МОНГОЛЫН
ҮНДЭСНИЙ ОЛОН НИЙТИЙН
РАДИО, ТЕЛЕВИЗ**

210524 Улаанбаатар хот, Баянгол дүүрэг,
Хувьсгалын зам 3, Утас/Факс: 32-16-14,
E-mail: mrtv@magicnet.mn

2007-01-12 № 24

танай _____-ны № _____-т

Аудитын тайлангийн төсөлд
санал хүргүүлэх тухай

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ
АУДИТЫН ГАЗРЫН ХОЁРДУГААР
ГАЗРЫН ЗАХИРАЛ О.МЭНДБАЯР
ТАНАА

Тайлбар 2-ийг үзнэ үү.

Бид танай газрын гүйцэтгэлийн аудитын тайланг хүлээн авч танилцлаа. Тайланд дурдагдсан зөрчил, дутагдлыг засч, залруулан өгсөн зөвлөмжүүдийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж, бүх талын арга хэмжээ авч ажиллах болно. Шалгалтын үр дүн нь бидний ажилд олон талын тус дэм болно гэдэгт найдаж байна.

Тавигдсан актуудаас "Зориулалт бусаар олгосон хөрөнгийг нөхөн төлүүлэх тухай" 02 тоот актыг харилцан ойлголцох нь зүйтэй гэж үзэж байна.

Төсвийн зардлын хэмнэлтээс сан байгуулж байгаагүй боловч, бодит хэмнэлтийн эх үүсвэрээр РТХЭГ-ын /хуучин нэрээр/ тогтмол цалинтай ажилтнуудад урамшуулал олгож байжээ. Тогтмол цалинтай ажилтнууд нь төсвийн сүлжээгээр цалинждаг, нийгмийн асуудлыг нь тухайн үед харж үзэх өөр боломж хомс байсан байна.

Актад дурдагдсан РТХЭГ-ын даргын "Хэмнэлтийн урамшууллын сан байгуулах, түүнийг зарцуулах журам, сангийн зөвлөлийг батлах тухай" 1999 оны 8 дугаар сарын 16-ны А/127 тоот тушаалыг 2000 оны 7 дугаар сарын 18-ны өдрийн "Хэмнэлтийн урамшууллын сан" байгуулах тухай А/130 тоот тушаалаар өөрчлөн найруулж, хүчингүй болгосон байна.

2000 оны 7 дугаар сарын 18-ны өдрийн "Хэмнэлтийн урамшууллын сан" байгуулах тухай А/130 тоот тушаал нь Монгол Улсын Засгийн газрын 1998 оны 6 дугаар сарын 23-ний өдрийн 106-р тогтоолын 3-р бүлгийг иш үндэс болгожээ.

Дээрхи 2000 оны А/130 тоот тушаалын дагуу тамгын хэлтсийн даргын тодорхойлолтыг үндэслэн тогтмол цалинтай ажилчдад 2006 оны 2 дугаар улирал хүртэл шагнал урамшил олгож байжээ. РТХЭГ татан буугдсан ч энэхүү 2000 оны А/130 тоот тушаалыг дагаж мөрдөж ирсэн байна.

Иймд "Зориулалт бусаар олгосон хөрөнгийг нөхөн төлүүлэх тухай" 02 тоот актыг хөнгөлүүлж, чөлөөлүүлэх саналтай байна.

Хууль батлагдаж, шинэчлэн зохион байгуулагдах шилжилтийн үеийн хүндрэл бэрхшээлтэй байсан нөхцөл байдлыг харгалзан үзэж бидний санал, хүсэлтийг нааштайгаар шийдвэрлэж өгнө үү.



ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ

М.НАРАНБААТАР

10 024

Үндэсний аудитын газрын тайлбар

Төрийн аудитын тухай хуулийн 19.3.2-т заасныг үндэслэн дараахь тайлбарыг өгч байна. Үүнд:


Тайлбар 1

Хяналтын зөвлөлийн дарга, гишүүдийг Үндэсний зөвлөлийн гишүүдийн дундаас томилсон нь хяналтын хараат бус байдлын зарчимд нийцэхгүй байна гэж үзсэн. Олон нийтийн радио, телевизийн тухай хуульд энэ асуудлыг тодорхой тусгах шаардлага бий.

Тайлбар 2

“Хэмнэлтийн урамшууллын сан” байгуулж хуримтлал үүсээгүй байхад Хэрэг эрхлэх газрын захиргааны ажилтнуудад 2005 он, 2006 оны эхний хагас жилийн байдлаар олгосон 6096.4 мянган төгрөгийг төлбөрөөс чөлөөлөх үндэслэлгүй байна.

МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ОЛОН НИЙТИЙН РАДИО,ТЕЛЕВИЗ



**Тендер шалгаруулалтгүйгээр, бараа, ажил, үйлчилгээний
гүйцэтгэгчийг сонгосон худалдан авалт**

(төгрөгөөр)

№	Огноо	Бэлтгэн нийлүүлэгч	Гүйлгээний утга	Үнийн дүн
1	2005.1.27	Универсал бат ХХК	ГК ламп 2ш	4,840,000
2	2005.1.27	РФ ХХК	100 вт нэвтрүүлэгч 1ш	2,890,000
3	2005.1.28	Инвест Кредит ХХК	03-83 УБЗ рулийн аппарат	1,050,525
4	2005.1.29	Вагнер Ази ХХК	03-83 УБЗ сэлбэг	858,294
5	2005.1.30	СБМ ХХК	Компьютер Р-4 1ш	990,000
6	2005.2.18	Инвест Кредит ХХК	600 студийн сэлбэг	10,500,000
7	2005.2.18	Хатан сүлд ХХК	Дуу хуулгын систем	14,500,000
8	2005.2.22	Хөрст авто сервис	Явуулын станцын сэлбэг	5,000,000
9	2005.2.23	Бизъяа	Компьютер Р-4 1ш	1,525,810
10	2005.3.23	СБМ ХХК	Өрөөний засвар	7,976,000
11	2005.3.24	Ленд энд Хаус ХХК	Сантехникийн сэлбэг	10,000,000
12	2005.3.17	Хатан сүлд ХХК	Дууны систем	13,000,000
13	2005.3.20	Вагнер Ази ХХК	03-83 УБЗ сэлбэг	493,752
14	2005.4.13	Вагнер Ази ХХК	03-83 УБЗ сэлбэг	2,370,000
15	2005.4.15	Харгиа ХХК	Дизель станц	15,000,000
16	2005.4.14	Уран уургач ХХК	Техникийн сэлбэг	12,011,560
17	2005.4.19	Хөрст авто сервис	Сэлбэг	7,760,000
18	2005.5.10	Силикон софт ХХК	Программ хангамж	2,000,000
19	2005.5.10	Өлзийт Жонон ХХК	Сэлбэг	4,900,000
20	2005.5.24	Буман төгрөг ХХК	Компьютер Р-4 3ш	3,150,000
21	2005.5.19	Алтан дэлгэр ХХК	03-83 УБ сэлбэг	280,000
22	2005.5.16	Эрчим автоматик	Сантехникийн сэлбэг	3,028,500
23	2005.6.16	Хөрст авто сервис	Тайм бэйс корректор	5,820,000
24	2005.6.10	СБМ ХХК	Тоног төхөөрөмж	4,504,802
25	2005.7.8	УТБ академи	Компьютер	2,400,000
26	2005.7.21	Вагнер Ази ХХК	03-83 УБ сэлбэг	266,504
27	2005.8.17	Нью ази ХХК	Принтерийн хор	1,358,000
28	2005.8.23	Вагнер Ази ХХК	03-83 УБ сэлбэг	1,207,370
29	2005.8.17	Хөрст авто сервис	03-83 УБ сэлбэг	368,600
30	2005.8.31	Нью ази ХХК	Материал	2,724,207
31	2005.9.20	Хатан сүлд ХХК	Эфирийн тоног төх/ж	24,440,000
32	2005.9.30	Сантехресурс ХХК	Сэлбэг	19,800,000
33	2005.10.14	Хөрст авто сервис	03-83 УБ сэлбэг	600,000
34	2005.10.14	Хатан сүлд ХХК	Эфирийн тоног төх/ж	12,049,900
35	2005.10.21	Хөрст авто сервис	Хүчдэл хувиргагч	4,312,000
36	2005.11.25	Хөрст авто сервис	03-83 УБ сэлбэг	2,410,450
37	2005.11.30	Нью ази ХХК	Принтер канон	2,716,000
38	2005.11.30	Декора ХХК	Давтамж хувиргагч	6,000,000
39	2005.3.9	Мөнхзул	Тоёота машин	4,353,457
40	2005.3.11	Ганзориг	Делика автомашин	5,692,484
41	2005.3.18	Лхагвадаш	Техникийн сэлбэг	13,929,300
42	2005.5.17	Цагаан	Сэлбэг	15,029,700
43	2005.5.19	Нью ази ХХК	Тоног төхөөрөмж	9,703,259
44	2005.1.20	Вагнер Ази ХХК	03-83 аккумулятор	493,410
45	2005.1.20	Дагвын Гэрэлмаа	03-83 автомат кроп	4,218,287
46	2006.2.13	Вагнер Ази ХХК	03-83 үйлчилгээний хөлс	635,768
47	2006.5.16	Ц.Энхбаяр	Тоног төхөөрөмж	40,199,475
Бүгд дүн				309,357,414

Орон даяар МУТВ-ийн нэвтрүүлгийн үйлчилгээний хөлсийг хураан төвлөрүүлж байгаа судалгаа

Нэр ангилал	ТВ-ийн нэвтрүүлгийн үйлчилгээний хөлс төлдөг өрх		ТВ-ийн нэвтрүүлгийн үйлчилгээний хөлс авах боломжгүй өрх								Төлөхөөс татгалздаг өрх		Нийт ТВ-тэй өрх	
			Нэвтрүүлэг үзэж чалдаггүй өрх		Нэн ядуу өрх		Эрчим хүчгүй өрх		Кабелийн ТВ-тэй төлдөггүй өрх					
	Тоо	мян.төг	Тоо	мян.төг	Тоо	мян.төг	Тоо	мян.төг	Тоо	мян.төг	Тоо	мян.төг	Тоо	мян.төг
Улаанбаатар хотын орон сууцгай айл өрх	53,558	706,965.6											53,558	706,965.6
Улаанбаатар хотын гэр хороололын айл өрх	16,725	220,770.0	30,000	396,000	20,000	264,000	-	-			27,700	365,640	94,425	1,246,410
Улаанбаатар хотын байгууллага, аж ахуйн нэгж	1,313	25,997.4									687	13,602.6	2,000	39,600
Аймгийн төв томоохон хот суурин газруудын айл өрх	29,411	299,992.2					10,000	102,000	10,000	102,000	11,913	121,512.6	61,324	625,504.8
Сум, багуудын айл өрх	4,305	30,996.0			8,000	57,600	2,000	14,400			11,195	80,604	25,500	183,600.0
Хөдөөгийн малчид													-	-
Бүгд	105,312	1,284,721	30,000	396,000	28,000	321,600	12,000	116,400	10,000	102,000	51,495	581,359.2	236,807	2,802,080.4

Жич : Засгийн газраар батлагдаж буй байгууллага аж ахуйн нэгжийн шинэчлэгдсэн тарифыг сард 2500 төгрөгөөр тогтоовол жилд 20.400.000 төгрөгөөр нэмэгдэх бололцоотой.

МРТХЭГ-ЫН АЖИЛТНУУДАД ОЛГОСОН УРАМШУУЛАЛ

(төгрөгөөр)

№	Овог нэр	2005 онд				2006 онд	Дүн
		1-р улиралд	2-р улиралд	3-р улиралд	4-р улиралд	1-р улиралд	
1	Л.Мягмар	52,905	62,034	83,731	78,858	74,116	351,644
2	Бо.Цэцэгмаа	52,905	62,034	83,731	78,858	103,763	381,291
3	Д.Баярсайхан	52,905	62,034	83,731	78,858	103,763	381,291
4	Б.Батзаяа	42,324	41,356	55,821	45,062	74,116	258,679
5	Ю.Өнөр	21,162	41,356	69,776	78,858	88,940	300,092
6	Ж.Батбаяр	42,324	41,356	55,821	45,062	74,116	258,679
7	Ж.Наранцэцэг	31,743	31,018	41,865	33,796	59,293	197,715
8	З.Минжинбаяр	21,162	20,680	41,865	33,796	44,470	161,973
9	А.Цогтбаяр	42,324	41,356	55,821	45,062	74,116	258,679
10	Ба.Цэцэгмаа	31,743	31,018	41,865	33,796	59,293	197,715
11	П.Алимаахүү	31,743	31,018	41,865	33,796	59,293	197,715
12	П.Сандагдорж	42,324	41,356	41,865	45,062	-	170,607
13	Б.Онгонцэцэг	31,743	31,018	27,910	33,796	59,293	183,760
14	С.Буянбат	31,743	-	-	-	-	31,743
15	А.Өлзий-Очир	31,743	31,018	27,910	33,796	59,293	183,760
16	Т.Батзориг	42,324	41,356	55,821	45,062	-	184,563
17	Г.Цэгмид	31,743	31,018	41,865	33,796	-	138,422
18	Л.Болдбаатар	31,743	31,018	41,865	33,796	59,293	197,715
19	С.Чулуунчөдөр	42,324	51,696	55,821	45,062	59,293	254,196
20	Б.Алтансүх	42,324	41,356	55,821	45,062	74,116	258,679
21	Р.Болормаа	42,324	41,356	55,821	45,062	88,940	273,503
22	Ш.Бадамханд	31,743	31,018	41,865	45,062	59,293	208,981
23	И.Бадамханд	31,743	31,018	41,865	33,796	88,940	227,362
24	Ч.Ерөөлсүрэн	31,743	-	41,865	-	-	73,608
25	Б.Содгэрэл	42,324	31,018	41,865	33,796	-	149,003
26	Хүрэлбаатар	31,743	31,018	27,910	-	-	90,671
27	Н.Эрдэнэбаяр	31,743	31,018	41,865	33,796	59,293	197,715
28	Ш.Намуунбайгаль	31,743	41,356	55,821	-	-	128,920
29	С.Энхжаргал	31,743	31,018	41,865	33,796	59,293	197,715
Бүгд дүн		1,058,100	1,033,916	1,395,512	1,126,542	1,482,326	6,096,396

МҮОНРТ-ийн 2005 он, 2006 оны эхний хагас жилийн төсвийн хөрөнгийн зарцуулалт, төрийн өмчийг олон нийтийн өмчид шилжүүлсэн байдалд хийсэн аудитаар илэрсэн төлбөр зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөгөөр)

№	Байгууллагын нэр	Төлбөр зөрчлийн агуулга	Төлбөрийн дүн	Зөрчлийн дүн	Нийт
1	МҮОНРТ	төлбөрийг нөхөн төлүүлэх тухай	2000		2000
2	МҮОНРТ	зориулалт бусаар олгосон хөрөнгийг нөхөн төлүүлэх тухай	6096.4		6096.4
3	МҮОНРТ	автомашинуудын үнийг төлүүлэх тухай			
4	МҮОНРТ	илэрсэн зөрчлийг арилгуулах тухай		6533.3	6533.3
	Бүгд дүн		8096.4	6533.3	14629.7